

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООГ
САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Аудитын код: ГНАГ-2024/19-ШТА-ГА

Даланзадгад хот 2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Аудитор Т.Хишигбат

Утас: 70533552 Цахим хаяг: Khishigbatt@audit.gov.mn

Аудитор Г.Амарзаяа

Утас: 70533552 Цахим хаяг: Amarzayag@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу: Цахим хаяг: www.audit.mn



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/87

Даланзадгад сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ийн 18.9, Монгол улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар болон Өмнөговь аймгийн Засаг даргад тус тус хүргүүлэхийг аудитор (Т.Хишигбат)-т үүрэг болгосугай.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөх албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитор (Т.Хишигбат)-т даалгасугай.



Ц.ӨСӨХБАЯР

016010115



ГАРЧИГ

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	3
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	4
Аудитын зорилго.....	4
Аудитын хамарсан хүрээ.....	4
Аудитын арга зүй.....	4
Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:.....	4
Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:	5
БҮЛЭГ-1 ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	6
А.1. Төрийн байгууллагад ажиллаж буй албан хаагчдын тоо жил бүр өссөн байна.	6
А.2. Төрийн байгууллагын хүний нөөцийн удирдлага үр дүнтэй байна.....	3
БҮЛЭГ-2 ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА. 6	
Б.1. Төрийн албанд жендерийн тэнцвэртэй байдлыг хангаж ажиллахгүй байна.	6
Б.2. Иргэд төрийн үйлчилгээг орон зайнаас хамааран авах нөхцөл боломж бүрдсэн байна.	8
Б.3. Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдалд иргэд сэтгэл ханамжтай байна.	10
ДҮГНЭЛТ.....	13
ЗӨВЛӨМЖ.....	14
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	15



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХГБХХГ	Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн төсөвт үйлдвэрийн газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ТҮЦ	Төрийн үйлчилгээний цахим

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт-1. Өмнөговь аймаг дахь төрийн байгууллага, түүнд хамаарах төрийн албан хаагчийн 2023 оны тоо мэдээлэл, сумдаар

Хүснэгт-2. Өмнөговь аймаг дахь төрийн албан хаагчийн тоон мэдээлэл, сумдаар 2021-2023 он

Хүснэгт-3. Өмнөговь аймаг дахь төрийн албан хаагчийн нийт хүн амд эзэлж буй хувь

Хүснэгт-4. Шинээр байгуулсан улсын төсөвт үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын мэдээлэл

Хүснэгт-5. Төрийн албаны сул орон тоог нөхөн ерөнхий, тусгай шалгалтын мэдээлэл

Хүснэгт-6. Төрийн байгууллагын 2017-2023 оны төрийн албан хаагчийн хүйсийн мэдээлэл

Хүснэгт-7. Хэрэглэгчийн үнэлгээний судалгаанаас гарсан сумдын дундаж үнэлгээ /2021-2023 он/

Хүснэгт-8. Холбогдох үйлчилгээний талаарх мэдээллийн хангалттай, ил тод, нээлттэй байдлын үнэлгээ 2021, 2022 он

График-1. Аймгийн нийт төрийн албан хаагчийн тоо 2017-2023 он

График-2. Төрийн албан хаагчийн дэмжлэгт хамруулсан байдал 2021-2024 он

График-3. Төрийн байгууллага хооронд шилжин ажилласан албан хаагчдын тоо 2019-2023 он

Зураг-1. ТАЗ-ийн Өмнөговь аймаг дахь салбар зөвлөлийн мэдээллийн самбар

Зураг-2. Төрийн албаны зөвлөлийн csc.gov.mn сайтын мэдээллийн бүтэц

Зураг-3. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр иргэдэд хүргэж буй байдал

Зураг-4. Төрийн албаны шалгалтад бүртгүүлэх, шалгалтын дүн харах цахим систем

Зураг-5. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр иргэдэд хүргэж буй байдал

Зураг-6. Сумдын Засаг даргын Тамгын газар ISO 9001:2015 стандарт нэвтрүүлсэн байдал

Зураг-7. Явуулын оффис арга хэмжээ 2022 он, 2023 он

Зураг-8. Өмнөговь И-оффис цахим системийн бүтэц, зохион байгуулалт



Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд, Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын зорилго

Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, хууль эрх зүйг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдсэн эсэх,
- Төрийн байгууллагуудын хүний нөөцийн тогтолцоо нь сайн засаглалыг бий болгож байгаа эсэх,

Аудитын хамарсан хүрээ

Аудитад төрийн зорилт, чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлдэг төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа явуулдаг бүтэц, зохион байгуулалттай төрийн захиргааны, тусгай, үйлчилгээний байгууллагуудын хүний нөөцийн, бодлогын хяналт шинжилгээ дотоод аудитын албад нь өөрийн болон өөрт хамаарах байгууллагуудын хүний нөөцийн бодлогыг оновчтой зөв тодорхойлсон, боловсруулсан, баталгаажуулсан байдлыг үзсэн.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, судалгаа явуулах, ярилцлага хийх арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж бэлтгэсэн.

Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад асуудлын шинжилгээний дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон улсын төсвийн санхүүжилтээр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Авлигын эсрэг хууль;
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Байгууллагын нууцын тухай хууль;
- Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль;
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;



- Захиргааны ерөнхий хууль;
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль;
- Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль;
- Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль
- Төрийн болон албаны нууцын тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль;
- Хууль тогтоомжийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Төрийн байгууллагын хүний нөөцийн бусад холбогдох эрх зүйн актууд.


Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул хэрэгжүүлж, аудитор Т.Хишигбат, Г.Амарзаяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн.

**БҮЛЭГ-1 ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.****А.1. Төрийн байгууллагад ажиллаж буй албан хаагчдын тоо жил бүр өссөн байна.**

1.1 Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т “Төрийн албаны төв байгууллага төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх бөгөөд уг бүртгэлд төрийн албан тушаал эрхэлж байгаа, эрхэлж байсан мэдээлэл болон энэ хуулийн 10.1.2, 10.1.4-т заасан удирдах албан тушаалтны нөөцийн бүртгэлийг тусгасан байна” заалтын дагуу Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2017-2023 оны үйл ажиллагааны тайлангаар төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг гаргасан байна.

График-1. Аймгийн нийт төрийн албан хаагчийн тоо 2017-2023 он



Эх сурвалж: Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2017-2023 оны үйл ажиллагааны тайлан

1.2 Дээрх графикаас харахад аймгийн төрийн албан хаагчдын тоо 2017 оноос 2018 онд 171 албан хаагчаар буурсан боловч 2018 оноос хойш тогтмол өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт-1. Өмнөговь аймаг дахь төрийн байгууллага, түүнд хамаарах төрийн албан хаагчийн 2023 оны тоо мэдээлэл, сумдаар

№	Сумын нэр	Байгууллагын тоо	Төрийн албан хаагч	Үүнээс:			
				Төрийн захиргаа	Төрийн тусгай	Төрийн улс төр	Төрийн үйлчилгээ
1	Даланзадгад	56	2,551	441	181	23	1,906
2	Баяндалай	6	102	9	0	6	87
3	Баян-Овоо	6	94	8	0	6	80
4	Булган	6	103	13	0	7	83
5	Гурвантэс	8	225	9	0	8	208
6	Мандал-Овоо	6	90	7	0	5	78
7	Манлай	6	128	11	0	7	110
8	Ноён	6	119	9	0	5	105
9	Номгон	6	100	7	0	8	85
10	Сэврэй	6	98	7	0	6	85
11	Ханбогд	12	403	15	8	1	379
12	Ханхонгор	6	116	10	0	7	99
13	Хүрмэн	6	91	9	0	6	76
14	Цогт-Овоо	6	115	9	0	5	101
15	Цогтцэций	10	430	16	0	7	407
Нийт		152	4,765	580	189	107	3,889

Эх сурвалж: Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан

1.3 Дээрх хүснэгтээс харахад нийт төрийн албан хаагчдын 12.2%-г төрийн захиргаа, 4.0%-г төрийн тусгай, 2.2%-г төрийн улс төр, 81.6%-г төрийн үйлчилгээний албан хаагчид эзэлж байна.

1.4 Байгууллагын хүний нөөцийн талаарх мэдээллийг байнга ил тод, нээлттэй мэдээлж байхыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д “Мэдээлэл хариуцагч өөрийн хүний нөөцийн талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана” заасан байна. Үүнд:

- 8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл,
- 8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам,
- 8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм,
- 8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам,
- 8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ,
- 8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам,


1.5 Дээрх хуульд заасны дагуу Алсын хараа, эрхэм зорилго, танилцуулга, ажлын төлөвлөгөө, тогтоол шийдвэр, сул орон тооны судалгаа, зар, төрийн албан ерөнхий шалгалт, тусгай шалгалт, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалт зэрэг мэдээллийг нэгтгэн Төрийн албаны зөвлөлийн Өмнөговь аймаг дахь салбар зөвлөлийн самбарт ил тод, нээлттэй мэдээлсэн байна.



Зураг-1. ТАЗ-ийн Өмнөговь аймаг дахь салбар зөвлөлийн мэдээллийн самбар

1.6 Төрийн албаны зөвлөлийн Өмнөговь аймаг дахь салбар зөвлөл нь аймгийн төрийн байгууллагуудын төрийн албаны сул орон тоо нөхөх ерөнхий, тусгай шалгалтын мэдээлэл, дүн зэрэг мэдээллийг Монгол Улсын төрийн албаны зөвлөлд хүргүүлэн csc.gov.mn сайт, “Өмнөговь” цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд мэдээлдэг байна.

Зураг-2. Төрийн албаны зөвлөлийн csc.gov.mn сайтын мэдээллийн бүтэц



1.7 Дээрх сайтад Төрийн албаны зөвлөлийн Өмнөговь аймаг дахь салбар зөвлөлийн дарга, гишүүдийн мэдээлэл 2020 оноос хойш шинэчлэгдээгүй, үйл ажиллагааны мэдээлэл байхгүй байна.



1.8 Цаашид цахим сайтын мэдээллийн тогтмол шинэчлэх, үйл ажиллагааны талаарх мэдээллийг оруулж байх шаардлагатай байна.

1.9 Төрийн үйлчилгээний алба буюу Төрийн үйлчилгээ мэдээллийн төвд Төрийн 6 байгууллага, хувийн хэвшлийн 14 байгууллага, цахим үйлчилгээний E-Mongolia, ТҮЦ машин-Цахим лавлагаа, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын киоск, Хаан банкны киоск, Гэрэгэ киоск лавлагааны болон төлбөрийн үйлчилгээний 5 төхөөрөмж үйл ажиллагаа явуулан иргэдэд түргэн шуурхай төр, хувийн хэвшлийн үйлчилгээг үзүүлж байна.

1.10 Төрийн үйлчилгээ мэдээллийн төвд төрийн 6 байгууллага 82 төрлийн үйлчилгээ үзүүлж байна. Үүнд:

- Төрийн үйлчилгээний алба
- Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
- Нийгмийн даатгал
- Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газар
- Сум дундын ойн анги
- Татварын хэлтэс
- Улсын өмгөөлөгч

1.11 Цахим үйлчилгээний 5 төхөөрөмж дараах үйлчилгээ, лавлагааг үзүүлдэг байна. Үүнд:

- E-Mongolia /560 төрлийн лавлагаа мэдээлэл/
- Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын киоск /18 төрлийн үйлчилгээ/
- Гэрэгэ киоск /Төлбөрийн 108 төрлийн үйлчилгээ. Авто машин торгууль, татвар, улсын бүртгэлийн төлбөр хураамж г.м/
- Хаан банк киоск /Хаан банкны бүх төрлийн үйлчилгээ/
- ТҮЦ машин-Лавлагаа мэдээлэл/ 28 төрлийн лавлагаа/

Зураг-3. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр иргэдэд хүргэж буй байдал



1.12 Төрийн үйлчилгээ мэдээллийн төвөөр 2021 онд /давхардсан тоогоор/ иргэн, 2022 онд 105,067 /давхардсан тоогоор/ иргэн, 2023 онд /давхардсан тоогоор/ иргэнд үйлчилсэн байна.

1.13 Төрийн байгууллагын үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй байхад анхаарч ажилдаг байна.

1.14 Аймгийн төрийн байгууллага болон төрийн албан хаагчид хүн амын төвлөрөл ихтэй сумдад бусад сумдаас илүү олон байдаг байна.



Хүснэгт-3. Өмнөговь аймаг дахь төрийн албан хаагчийн тоон мэдээлэл, сумдаар 2021-2023 он

№	Сумын нэр	Төрийн албан хаагчийн тоо			Хүн амын тоо		
		2021 он	2022 он	2023 он	2021 он	2022 он	2023 он
1	Даланзадгад	2,214	2,368	2,551	28,854	29,645	31,601
2	Баяндалай	97	109	102	2,083	2,049	1,947
3	Баян-Овоо	94	98	94	1,853	1,768	1,650
4	Булган	90	105	103	2,059	2,017	1,900
5	Гурвантэс	248	223	225	5,316	5,283	5,306
6	Мандал-Овоо	90	89	90	1,629	1,598	1,503
7	Манлай	122	131	128	2,735	2,654	2,575
8	Ноён	104	107	119	1,385	1,362	1,315
9	Номгон	93	102	100	2,498	2,462	2,232
10	Сэврэй	98	95	98	2,015	1,967	1,807
11	Ханбогд	441	378	403	8,404	8,533	8,941
12	Ханхонгор	105	107	116	2,014	1,989	1,872
13	Хүрмэн	82	88	91	1,560	1,551	1,455
14	Цогт-Овоо	116	112	115	1,939	1,921	1,855
15	Цогтцэций	393	440	430	8,599	9,149	10,194

Эх сурвалж: Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2021-2023 оны үйл ажиллагааны тайлан,
Үндэсний статистикийн хорооны тайлан 2021-2023 он

1.15 Дээрх хүснэгтээс харахад хүн амын төвлөрөл ихтэй сумдад буюу Даланзадгад, Гурвантэс, Ханбогд, Цогтцэций зэрэг сумдад төрийн албан хаагчдын тоо их байна.

Хүснэгт-4. Өмнөговь аймаг дахь төрийн албан хаагчийн нийт хүн амд эзэлж буй хувь

№	Сумын нэр	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
1	Даланзадгад	8.3%	7.7%	7.4%	0.0%	7.7%	8.0%	8.1%
2	Баяндалай	4.8%	4.3%	4.4%	0.0%	4.7%	5.3%	5.2%
3	Баян-Овоо	5.0%	4.6%	4.4%	0.0%	5.1%	5.5%	5.7%
4	Булган	4.1%	3.7%	4.0%	0.0%	4.4%	5.2%	5.4%
5	Гурвантэс	4.4%	4.1%	4.1%	0.0%	4.7%	4.2%	4.2%
6	Мандал-Овоо	5.1%	5.0%	5.2%	0.0%	5.5%	5.6%	6.0%
7	Манлай	3.6%	3.5%	4.0%	0.0%	4.5%	4.9%	5.0%
8	Ноён	6.5%	6.1%	6.2%	0.0%	7.5%	7.9%	9.0%
9	Номгон	3.4%	3.5%	3.3%	0.0%	3.7%	4.1%	4.5%
10	Сэврэй	4.3%	4.1%	4.0%	0.0%	4.9%	4.8%	5.4%
11	Ханбогд	4.4%	3.0%	3.8%	0.0%	5.2%	4.4%	4.5%
12	Ханхонгор	4.9%	4.6%	4.4%	0.0%	5.2%	5.4%	6.2%
13	Хүрмэн	5.1%	5.3%	4.5%	0.0%	5.3%	5.7%	6.3%
14	Цогт-Овоо	5.0%	4.5%	4.8%	0.0%	6.0%	5.8%	6.2%
15	Цогтцэций	3.9%	3.6%	4.0%	0.0%	4.6%	4.8%	4.2%

Эх сурвалж: Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2021-2023 оны үйл ажиллагааны тайлан,
Үндэсний статистикийн хорооны тайлан 2021-2023 он

1.16 Дээрх хүснэгтээс харахад хүн ам ихтэй сумдад төрийн албан хаагчийн тоо их боловч Гурвантэс, Ханбогд, Цогтцэций, Номгон сумын нийт хүнд амд эзлэх төрийн албан хаагчийн хувийг бусад сумтай харьцуулахад бага байна.



1.17 Цаашид төрийн албан хаагчийн тоог нийт хүн амд эзлэх хувийн дундажтай харьцуулан хуваарилбал төрийн байгууллагын үйлчилгээ иргэдэд илүү хүртээмжтэй байх боломжтой байна.

А.2. Төрийн албаны салбар зөвлөлд төрд учир хохирлын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

2.1 Аймгийн ИТХ-ын 2022 оны 5/19 дүгээр тогтоолоор Сэврэй, Цогт-Овоо сумын Ойн анги УТҮГ, 6/17 дугаар тогтоолоор Цэмцгэр Өмнөговь ОНӨААТҮГ, 2023 оны 15/02 дугаар тогтоолоор Худалдааны төв зах ОНӨААТҮГ, 2024 оны 19/02 дугаар тогтоолоор Говь дент анхны цахиур ОНӨААТҮГ, 2024 оны 19/03 дугаар тогтоолоор Итгэлтэй амьдрал төв ОНТҮГ-г тус тус шинээр үүсгэн байгуулсан байна.

2.2 Аймгийн ИТХ-ын 2024 оны 19/02, 19/03 дугаар тогтоол, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйл 18.3-д “Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүрэгээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно” заалтыг үндэслэн 2 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулсан байна.

Хүснэгт-5. Шинээр байгуулсан улсын төсөвт үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын мэдээлэл

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Өмчийн хэлбэр
1	Говь дэнт анхны цахиур	Амны хөндий урьдчилан сэргийлэх, туслан зөвлөх үйлчилгээ	ОНӨААТҮГ
2	Итгэлтэй амьдрал төв	Архи согтууруулах ундаа, мансууруулах бодисын хамаарал бүхий иргэдэд биеийн болон сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, соён гэгээрүүлэх, сургалт зохион байгуулах	ОНӨААТҮГ

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоол


2.3 Говь дэнт анхны цахиур, Итгэлтэй амьдрал төв ОНӨААТҮГ нь шинээр байгуулсан нь Монгол Улсын MNS 5095:2017 стандартад заасан БОЭТ-н шүдний үзлэг, оношилгоо, эмчилгээ, жижиг мэс ажилбар, сэтгэцийн эмгэг, наркологийн тусламж, үйлчилгээтэй чиг үүргийн хувьд давхардсан байна.

2.4 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 09 дүгээр тогтоолоор “Төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тусламж дэмжлэг үзүүлэх журам”-г баталсан байна.

2.5 Тус журмын 7.1.2-т “Дэмжлэгийн хэмжээ”, 7.1.2.1-т “Орон сууцны ипотекийн зээлд хамрагдсан болон шинээр орон сууц худалдан авах, хувийн орон сууц барихад зориулж төрийн албан хаагчийн ажилласан ажил, ажлын үр бүтээлийг харгалзан төрийн албан 5-10 жил ажилласан бол 8 сая хүртэл, төрийн албан 11-15 жил ажилласан бол 10 сая хүртэл, 16 ба түүнээс дээш жил ажилласан бол 20 сая төгрөг хүртэл төгрөгийн дэмжлэг үзүүлнэ”, 7.1.2.2-т “Хашаа, байшин болон гэрт амьдарч буй төрийн албан хаагчид амьдрах нөхцөлөө /шинээр хашаандаа байшин барих, цэвэр бохирын шугам, дулааны шугамд холбогдох/ сайжруулахад нь зориулж 5-10 жил ажилласан бол 5 сая хүртэл, төрийн албан 11-15 жил ажилласан бол 8 сая хүртэл, 16 ба түүнээс дээш жил ажилласан бол 20 сая төгрөг хүртэл төгрөгийн дэмжлэг үзүүлнэ”, 7.1.2.3-т “Онцгой амжилт гаргаж, үр бүтээлтэй ажилласан төрийн албан хаагчид орон сууцны нөхцөлөө сайжруулахад нь зориулж 8 сая хүртэл төгрөгийн дэмжлэгийг 1 удаа үзүүлж болно” гэж заасан байна.



График-2. Төрийн албан хаагчийн дэмжлэгт хамруулсан байдал 2021-2024 он



Эх сурвалж: Засаг даргын ерөнхий дансны 2021-2024 оны төсвийн гүйцэтгэл

2.6 Дээрх графикаас харахад төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн албан хаагчийн тоо болон мөнгө дүн жил бүр өссөн бөгөөд 2024 оны 3 дугаар улирлын байдлаар өмнө оноос 181 албан хаагчаар өссөн байна.

2.7 Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт төрийн албан хаагчдыг орон нутагт тогтвор суурьжилтай ажиллуулах зорилгоор “Нутгийн дэм” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

2.8 Тус хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн байгууллагын төрийн захиргааны албан хаагчдад 210,000 төгрөг, төрийн үйлчилгээний албан хаагчдад 610,000 төгрөг, улсын төрийн болон улсын төсвийн байгууллагын албан хаагчдад 400,000 төгрөгийг сар бүр олгож байна.

2.9 Дээрх хөтөлбөрөөс 2021 онд 1,444.4 сая төгрөг 4,791 албан хаагч, 2022 онд 1,444.8 сая төгрөг 4,983 албан хаагч, 2023 онд 19,639.7 сая төгрөг 5,260 албан хаагчдад дэмжлэг болгон зарцуулсан байна.

2.10 Энэ нь төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгаагаар хангаад анхаарч ажилдаг болохыг харуулж байна.

2.11 Төрийн албаны зөвлөлийн Өмнөговь аймаг дахь салбар зөвлөл нь Төрийн албаны зөвлөлийн 33 дугаар зүйлийн 33.10-т “Төрийн албаны тусгай шалгалт авах талаар олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон төрийн албаны төв байгууллагын цахим хуудсаар нийтэд зарлан мэдээлнэ” заасны дагуу төрийн албаны сул орон тоог нөхөх ерөнхий, тусгай, төрийн үйлчилгээний удирдах ажилтны шалгалтын мэдээллийг csc.gov.mn сайт, “Өмнөговь” цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд мэдээлдэг байна.

Зураг-4. Төрийн албаны шалгалтад бүртгүүлэх, шалгалтын дүн харах цахим систем



"OPEN - EXAM" ШАЛГАЛТЫН ЦАХИМ СИСТЕМ МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

2.12 Төрийн албаны зөвлөлийн Өмнөговь аймаг дахь салбар зөвлөл нь Төрийн албан тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.7-д “Төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалтыг улиралд нэгээс доошгүй удаа зохион байгуулна” заасны дагуу улирал бүр бүр сул орон тоог нөхөх ерөнхий, тусгай, төрийн үйлчилгээний удирдах ажилтны шалгалтыг зохион байгуулсан байна.

Хүснэгт-6. Төрийн албаны сул орон тоог нөхөн ерөнхий, тусгай шалгалтын мэдээлэл

№	Огноо	Ерөнхий шалгалт өгч бүртгэгдсэн нөөц			Үүнээс төрийн албанд ажиллаж байгаа		
		Эмэгтэй	Эрэгтэй	Нийт	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт
1	2020	87	27	114	51	16	67
2	2021	90	39	129	52	26	78
3	2022	76	20	96	52	18	70
4	2023	110	28	138	88	34	122

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөлийн 2020-2023 оны үйл ажиллагааны тайлан

2.13 Дээрх хүснэгтээс харахад төрийн албаны шалгалтад тэнцэж, нөөцөд бүртгүүлсэн иргэдээс 2020 онд 58.8%, 2021 онд 60.5%, 2022 онд 72.9%, 2023 онд 88.4% болж нэмэгдсэн байна. Энэ нь төрийн албаны шалгалтад тэнцээд нөөцөд бүртгүүлснээр төрийн албан ажиллах боломжтойг харуулж байна.

2.14 Төрийн байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалд хамаарах бүтцийн нэгжийн удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтад тэнцсэн иргэд албан тушаалдаа бүрэн томилогдсон байна.

2.15 Төрийн албан хаагчийг төрийн албанаас хууль бусаар халсан, чөлөөлсөн, түр чөлөөлснийг тогтоосон 2019-2024 оны 3 дугаар улирлын байдлаар Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээр 14 албан хаагчийн 92.6 сая төгрөг болон эргүүлэн томилох шийдвэр гарсан байна.

2.16 Үүнээс 5 албан хаагчийн нэхэмжлэлийг Өмнөговь аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээр 2 албан хаагчийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, 3 албан хаагчийн 21.9 сая төгрөгийн нэхэмжлэлээс 13.2 сая төгрөг болгон бууруулж шийдвэрлэсэн байна.

2.17 Шүүхээр шийдвэрлүүлсэн 12 албан хаагчийн 76.4 сая төгрөгийн нэхэмжлэлээс 7 хүний 61.0 сая төгрөгийн нэхэмжлэлийг Иргэний тухай хуулийн 498 дугаар зүйлийн 498.2-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана” барагдуулсан байна.

2.18 Мөн Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 2 албан хаагчийн 14.6 сая төгрөгийн нэхэмжлэл төлөгдөөгүй, 3 албан хаагчийн 0.7 сая төгрөгийн нэхэмжлэлийг барагдуулж, албан тушаалд нь эргүүлэн томилсон байна.



2.19 Захиргааны болон иргэний хэргийн шүүхээр 3 албан хаагчийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох, 2 албан хаагчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, албан тушаалд эргүүлэн томилохоор шийдвэрлэсэн байна.

2.20 Цаашид төрийн байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтнуудад хууль бус шийдвэр, түүний үр дагаврын тухай урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж байх шаардлагатай байна.

2.21 Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т “Төрийн албаны төв байгууллага төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх бөгөөд уг бүртгэлд төрийн албан тушаал эрхэлж байгаа, эрхэлж байсан мэдээлэл болон энэ хуулийн 10.1.2, 10.1.4-т заасан удирдах албан тушаалтны нөөцийн бүртгэлийг тусгасан байна. Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх”, заасны дагуу мэдээллийг чанаржуулах зорилгоор төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийг Иргэний бүртгэл, Боловсролын мэдээллийн сан, Хур, Төрийн албаны цалингийн нэгдсэн системтэй холбосон нь мэдээллийг боловсруулах, дамжуулах, солилцох, их өгөгдөл /data/-г ашиглах үйл ажиллагаанд үр нөлөө үзүүлж, бүртгэл мэдээллийн чанарт ахиц гарсан байна.



БҮЛЭГ-2 ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Б.1. Төрийн албанд жендерийн тэнцвэртэй байдлыг хангаж ажиллахгүй байна.

1.1 Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн байгууллага бүр "Сургалтын төлөвлөгөө"-г баталж төлөвлөгөөний дагуу 2021 онд 231 удаагийн сургалт, Насан туршийн боловсролын төвийн 154 удаагийн сургалтад 2,358 хүн, 2022 онд сургалтын төлөвлөгөөний дагуу 686 хүн, 2023 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 5,844 хүн ажлын байран дээрх сургалт, семинарын арга хэмжээг цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор цахим сургалтын орчныг бүрдүүлж, сургалт, мэдээллийг цахимаар зохион байгуулан ажиллалаа.

1.2 Төрийн албан шинэтгэлийн хүрээнд төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх сургалтыг тасралтгүй явуулж, зохион байгуулах, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “7:4:10” арга зүйн вебинар сургалтыг 7 хоног бүрийн Пүрэв гарагт уламжлал болгон тогтмол зохион байгуулдаг байна.

1.3 Тус сургалтаар Стратеги төлөвлөлт, Бодлого, шийдвэр, Ёс зүйн манлайлал, Харилцаа, хандлага, стресс менежмент, Систем, сэтгэлгээ, Түүх, соёл гэсэн 6 агуулгын хүрээнд 2021 онд 32 удаагийн сургалт мэдээлэлд 2100 гаруй, 2022 онд 8974 хүн, 2023 онд 28 удаагийн сургалтад 11,542 хүн хамрагдсан байна.




1.4 Төрийн жинхэнэ албан хаагчийг богино болон дунд хугацааны сургалтад 2021 онд 39 хүн, 2022 онд 36 хүн, 2023 онд 45 хүнийг сургалтын агуулга, хөтөлбөрийн хүрээнд мэргэшүүлэн сургасан байна.

1.5 Төрийн албан хаагчдыг орон зайнаас үл хамааран сургалтад хамруулсан байна.

1.6 Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т “Албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцож, эсхүл тухайн байгууллагад 10 ба түүнээс дээш жил нэг албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчийг удирдлагын санаачилгаар төрийн албаны нэг байгууллагаас нөгөө байгууллагад тэдгээрийн удирдлагын хооронд харилцан тохиролцсоны дагуу шилжүүлэн ажиллуулж болно” заасны дагуу төрийн албан хаагчдыг төрийн байгууллага хооронд албан хаагчдыг шилжүүлсэн байна.

График-3. Төрийн байгууллага хооронд шилжин ажилласан албан хаагчдын тоо 2019-2023 он



Эх сурвалж: Төрийн албаны зөвлөлийн Өмнөговь аймаг дахь салбар 2019-2023 оны үйл ажиллагааны тайлан

1.7 Төрийн байгууллага хооронд шилжин ажиллуулсан албан хаагчийн тоо жил бүр өсөж 2023 онд өмнөх оноос 25 албан хаагчаар өссөн байна.

1.8 Аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудад төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай төрийн албан хаагчийн буюу мэдээлэл технологийн албан хаагчийн орон тоотой 17 байгууллага байна.

1.9 Төрийн байгууллагуудад төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай төрийн албан хаагчийн буюу мэдээлэл технологийн албан хаагчийн ажлын байр дутмаг байна.

1.10 Төрөөс эрэгтэй, эмэгтэй хүний төрийн албанд орох, албан тушаал эрхлэх тэгш эрх бодитой хэрэгжих боломж, нөхцөлөөр хангах бодлого хэрэгжүүлэхийг Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т “Төрөөс эрэгтэй, эмэгтэй хүний төрийн албанд орох, албан тушаал эрхлэх тэгш эрх бодитой хэрэгжих боломж, нөхцөлөөр хангахын тулд дараах бодлого хэрэгжүүлнэ” заасан байна.

Хүснэгт-7. Төрийн байгууллагын 2017-2023 оны төрийн албан хаагчийн хүйсийн мэдээлэл

№	Огноо	Төрийн албан хаагчийн тоо	Үүнээс			
			Эрэгтэй	Хувиар	Эмэгтэй	Хувиар
1	2017	3,866	1,202	31.1%	2,664	68.9%
2	2018	3,695	1,068	28.9%	2,627	71.1%
3	2019	3,749	1,119	29.8%	2,630	70.2%
4	2020	4,075	1,076	26.4%	2,999	73.6%
5	2021	4,387	1,152	26.3%	3,235	73.7%



6	2022	4,552	1,107	24.3%	3,445	75.7%
7	2023	4,765	1,192	25.0%	3,573	75.0%

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөлийн 2017-2023 оны үйл ажиллагааны тайлан

1.11 Дээрх хүснэгтээс харахад төрийн байгууллагад ажиллаж буй эрэгтэйчүүдийн эзлэх хувь жил бүр буурч 2023 оны жилийн эцсийн байдлаар төрийн албан хаагчдын эрэгтэй 25%, эмэгтэй 75%-ийн харьцаатай байна.

1.12 Цаашид Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Төрийн ба төсөвт байгууллагын нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх бодлого, арга хэмжээг хүний нөөцийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх бөгөөд энэ хуулийн 6.5.6-д заасан тохиолдолд энэ заалт үл хамаарна” заасныг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Б.2. Иргэд төрийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран авах нөхцөл боломж бүрдсэн байна.

2.1 Төрийн үйлчилгээний алба буюу Төрийн үйлчилгээ мэдээллийн төвд Төрийн 6 байгууллага, хувийн хэвшлийн 14 байгууллага, цахим үйлчилгээний E-Mongolia, ТҮЦ машин-Цахим лавлагаа, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын киоск, Хаан банкны киоск, Гэрэгэ киоск лавлагааны болон төлбөрийн үйлчилгээний 5 төхөөрөмж үйл ажиллагаа явуулан иргэдэд түргэн шуурхай төр, хувийн хэвшлийн үйлчилгээг үзүүлж байна.

2.2 Төрийн үйлчилгээ мэдээллийн төвд төрийн 6 байгууллага 82 төрлийн үйлчилгээ үзүүлж байна. Үүнд:

- Төрийн үйлчилгээний алба
- Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
- Нийгмийн даатгал
- Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газар
- Сум дундын ойн анги
- Татварын хэлтэс
- Улсын өмгөөлөгч

2.3 Цахим үйлчилгээний 5 төхөөрөмж дараах үйлчилгээ, лавлагааг үзүүлдэг байна. Үүнд:

- E-Mongolia /560 төрлийн лавлагаа мэдээлэл/
- Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын киоск /18 төрлийн үйлчилгээ/
- Гэрэгэ киоск /Төлбөрийн 108 төрлийн үйлчилгээ. Авто машин торгууль, татвар, улсын бүртгэлийн төлбөр хураамж г.м/
- Хаан банк киоск /Хаан банкны бүх төрлийн үйлчилгээ/
- ТҮЦ машин-Лавлагаа мэдээлэл/ 28 төрлийн лавлагаа/

Зураг-3. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр иргэдэд хүргэж буй байдал




2.4 Төрийн үйлчилгээ мэдээллийн төвөөр 2020 онд 97,656 /давхардсан тоогоор/ иргэн, 2021 онд 98,269 /давхардсан тоогоор/ иргэн, 2022 онд 105,067 /давхардсан тоогоор/ иргэн, 2023 онд 118,190 /давхардсан тоогоор/ иргэнд үйлчилсэн байна.

2.5 Цахим технологи ашиглан иргэдэд төрийн үйлчилгээг хүргэхэд анхааран ажилласан байна.

2.6 Төрийн байгууллагын үйл ажиллагаа, орчин нөхцөлийг сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд жигд, хүртээмжтэй хүргэх зорилгоор Баяндалай, Баян-Овоо, Булган, Гурвантэс, Мандал-Овоо, Ноён, Ханхонгор, Хүрмэн, Цогт-Овоо сумдын Засаг даргын Тамгын газар нь үйл ажиллагаандаа Олон Улсын чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандарт нэвтрүүлж анхдагч баталгаажуулалт хийлгэн, 2024 он 2025 онд магадлах аудит хийлгэхээр ажиллаж байна.

Зураг-4. Сумдын Засаг даргын Тамгын газар ISO 9001:2015 стандарт нэвтрүүлсэн байдал



2.7 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, хөдөөгийн алслагдсан сум, баг, хилийн боомтод хүрч төрийн үйлчилгээг үзүүлэх зорилготой "Явуулын оффис" арга хэмжээг сум, багийн малчид, иргэдэд төрийн үйлчилгээг нэг цэгээс шуурхай хүргэх зорилгоор 2022 онд 88 төрийн албан хаагч 145 нэр төрлийн төрийн үйлчилгээ 6 сумын 19 багийн 10,136 /давхардсан тоогоор/ иргэнд, 2023 онд 32 төрийн албан хаагч 87 төрийн үйлчилгээг 13 сумын 26 багийн 16,320 /давхардсан тоогоор/ иргэнд хүргэж ажилласан байна.

Зураг-5. Явуулын оффис арга хэмжээ 2022 он, 2023 он




2.8 Орон нутагт төрийн үйлчилгээг жигд, хүртээмжтэй байхад анхаарч сумдын ЗДТГ-т ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэн, “Явуулын оффис” арга хэмжээг зохион байгуулсан байна.

Б.3. Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдалд иргэд сэтгэл ханамжтай байна.

3.1 Аймгийн Төрийн байгууллагууд нь төрийн үйлчилгээг иргэд хүргэх, байгууллагын албан хаагчдын мэдээлэл солилцох, албан бичиг, мэйл явуулах, групп чат үүсгэх, цаг бүртгэл хийх, Засаг даргын үйл ажиллагааны хэрэгжилт, аймгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөний систем, иргэдээс ирсэн өргөдөл, гомдол бүртгэх боломжтой Өмнөговь И-оффис программыг ашиглаж төрийн байгууллага хоорондоо уялдаа холбоотой ажиллаж байна.

3.2 Тус программ нь интернэт байгаа аль ч газраас нэвтэрч ажил үүргээ гүйцэтгэх боломжтой цахим систем юм.

Зураг-6. Өмнөговь И-оффис цахим системийн бүтэц, зохион байгуулалт



3.3 Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын бичиг баримын хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.6-д “... Захиргааны байгууллага салбарын болон орон нутгийн хэмжээнд бодлогын баримт бичгийн үр дүн, үр нөлөөг судлах, захиргааны байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хэрэглэгчийн үнэлгээ буюу судалгааг хийж болно. Хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын баталсан ерөнхий удирдамжийг баримтлан хөндлөнгийн байгууллагыг судалгааны болон хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагын дундаас ажлын туршлага, хүний нөөцийн хүчин чадал зэргийг харгалзан сонгон шалгаруулна” заасны дагуу Өмнөговь аймгийн ЗДТГ-аас зарласан сонгон шалгаруулалтад “Блү Пойнт” ХХК нь шалгарч, хэрэглэгчийн үнэлгээний судалгааны тайланг 2021 он, 2022 он, 2023 онд хийж гүйцэтгэсэн байна.

3.4 Тус үнэлгээг сумдын насан хүрсэн иргэнээс ганцаарчилсан ярилцлага, асуулга судалгааны аргаар мэдээлэл цуглуулан 1- маш муу, 2- муу, 3- дунд, 4- сайн, 5- маш сайн, 0-мэдэхгүй, хариулах боломгүй гэсэн сонголтоор дундаж үнэлгээг гарган 2021 онд 15 сумын



1,452 иргэнээс 3.7, 2022 онд 3.8, 2023 онд 13 сумын 1,723 иргэнээс 3.9-аар үнэлэгдсэн байна.

Хүснэгт-8. Хэрэглэгчийн үнэлгээний судалгаанаас гарсан сумдын дундаж үнэлгээ /2021-2023 он/

№	Сумдын нэр	2021 оны үнэлгээ	2022 оны үнэлгээ	2023 оны үнэлгээ	Сүүлийн 3 жилийн дундаж үнэлгээ
1	Баян-Овоо	3.7	3.5	3.97	3.7
2	Баяндалай	3.6	3.7	-	3.7
3	Булган	3.8	3.7	3.94	3.8
4	Гурвантэс	3.7	4.1	4.16	4.0
5	Даланзадгад	4.0	4.0	3.84	3.9
6	Мандал-Овоо	3.3	3.5	3.80	3.5
7	Манлай	3.2	3.5	3.71	3.5
8	Ноён	3.2	3.6	-	3.4
9	Номгон	3.8	3.8	3.87	3.8
10	Сэврэй	4.2	4.0	4.20	4.1
11	Ханбогд	3.7	3.7	3.36	3.6
12	Ханхонгор	3.5	3.7	4.07	3.8
13	Хүрмэн	3.9	3.8	4.07	3.9
14	Цогт-Овоо	4.0	3.9	4.15	4.0
15	Цогтцэций	3.8	3.8	3.29	3.6
Дундаж үнэлгээ		3.7	3.8	3.9	

Эх сурвалж: “Блү Пойнт” ХХК-ны гүйцэтгэсэн иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны тайлан 2021-2023 он

3.5 Дээрх хэрэглэгчийн дундаж үнэлгээ сүүлийн 3 жилд өссөн үзүүлэлттэй байна.

3.6 Судалгааны 2021, 2022 оны санал асуулгын 26.3-т Холбогдох үйлчилгээний талаарх мэдээллийн хангалттай, ил тод, нээлттэй байдал /самбар гэх мэт/ гэх асуултыг оруулсан байна.

Хүснэгт-9. Холбогдох үйлчилгээний талаарх мэдээллийн хангалттай, ил тод, нээлттэй байдлын үнэлгээ 2021, 2022 он

№	Хариулт	2021 он		2022 он	
		Хамрагдсан хүний тоо	Эзлэх хувь	Хамрагдсан хүний тоо	Эзлэх хувь
1	Маш муу 1	56	3.9	45	2.3
2	Муу	163	11.2	121	6.3
3	Дунд	749	51.6	855	44.5
4	Сайн	371	25.6	562	29.3
5	Маш сайн	29	2	247	12.8
6	Хариулаагүй	84	5.8	91	4.7
Хамрагдсан нийт иргэд		1452	100%	1921	100%
Дундаж үнэлгэ		2.99		3.35	

Эх сурвалж: “Блү Пойнт” ХХК-ны гүйцэтгэсэн иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны тайлан 2021, 2022 он

3.7 Судалгааны үр дүнгээр төрийн байгууллагын үйлчилгээний ил тод, нээлттэй байдалд иргэд сэтгэл ханамжтай байна.

3.8 Тус судалгааны үр дүнг үндэслэн аймгийн Засаг даргын 2022 оны А/1308, 2023 оны А/366, 2024 оны А/373 дугаар захирамжаар “Хэрэглэгчийн үнэлгээний мөрөөр ажил сайжруулах 2022 он, 2023 он, 2024 онд хэрэгжүүлэх, арга хэмжээний төлөвлөгөө”-г баталж



хэрэгжилтийг 2022 онд 91.3% дүгнэсэн бол 2023 оны тайланг дүгнээгүй, бол 2024 оны хэрэгжилт гарах хугацаа болоогүй байна.

3.9 Цаашид “Хэрэглэгчийн үнэлгээний мөрөөр ажил сайжруулах хэрэгжүүлэх, арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг дүгнэж байх шаардлагатай байна.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Төрийн байгууллагад ажиллаж буй албан хаагчдын тоо жил бүр өссөн байна.
- Төрийн байгууллагын хүний нөөцийн удирдлага үр дүнтэй байна.
- Төрийн албанд жендерийн тэнцвэртэй байдлыг хангаж ажиллахгүй байна
- Иргэд төрийн үйлчилгээг орон зайнаас хамааран авах нөхцөл боломж бүрдсэн байна.
- Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдалд иргэд сэтгэл ханамжтай байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Төрийн албаны зөвлөлийн Өмнөговь аймаг дахь салбарт:

- Төрийн байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтнуудад хууль бус шийдвэр, түүний үр дагаврын тухай урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж байх



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛ**


204 тоот, Нутгийн удирдлагын ордон, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976)70532849, Факс: (976)70532111,
И-мэйл: info@omnogovi.gov.mn, Вэб сайт: www.omnogovi.gov.mn

2024.11.20 № 106
танай _____-ны № _____-т

Г ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/162 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газраас хийж гүйцэтгэсэн "Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцоо, үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа. Тус тайланд Төрийн албаны зөвлөлийн Өмнөговь аймаг дахь салбараас саналгүй болно.

ДАРГА



Ц.АМАРТӨГС

4624170029